



ЭРҮҮЛ МЭНД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ, ТҮҮНИЙГ АШИГЛАХ НЬ



АГУУЛГА



- Удиртгал
- Ойлголт, тодорхойлолт
- Үзүүлэлтийн аргачлал

ᠮᠣᠩᠭᠡᠯᠠᠳᠤ ᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤ

УДИРТГАЛ



- ❑ “**Эрүүл мэнд**” гэж хүн өвчин эмгэггүй байх төдийгүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг хэлнэ.
- ❑ Хүн амын эрүүл мэндийн байдал, түүний хувьсал өөрчлөлтийг тодорхойлоход **эрүүл мэндийн статистик нь** чухал үүрэгтэй.
- ❑ Үндэсний ТХЗ-ын үнэлэх шалгуур үзүүлэлтүүдэд **эрүүл, мэнд нөхөн үржихүйн** үндсэн үзүүлэлтүүдийг оруулсан байдаг.



- “Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал”-ыг ҮСХ-ны даргын 2009 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 01/151 тоот тушаалаар баталж мөрдөж эхэлсэн.



ЭХИЙН ЭНДЭГДЛИЙН ХАРЬЦАА, ТҮВШИН



- Эхийн эндэгдлийн харьцаа (ЭЭХ) нь амьд төрсөн 100 000 хүүхдэд ногдох жирэмсэн буюу жирэмсний дараах, мөн хүүхэд төрүүлэх үеийн хүндрэлээс хамаарч нас барсан эхчүүдийн тоогоор илэрхийлэгдэнэ. **(ТХЗ. Зорилт-10.5.1)**

$$\text{Эхийн эндэгдлийн харьцаа} = \frac{\text{Нийт эндсэн эхийн тоо}}{\text{Нийт амьд төрөлтийн тоо}} * 100\ 000$$

- Эхийн эндэгдлийн түвшин (ЭЭТ) нь тухайн жилд 15-49 насны (төрөх насны) эмэгтэйчүүдэд ноогдох эндсэн эхийн тоогоор илэрхийлэгдэнэ.

$$\text{Эхийн эндэгдлийн түвшин} = \frac{\text{Нийт эндсэн эхийн тоо}}{\text{Нөхөн үржихүйн насны (15-49 насны) эмэгтэйчүүдийн тоо}} * 100\ 000$$



ХҮН АМЫН НАС БАРАЛТ, ТЭРГҮҮЛЭХ 10 ШАЛТГААНААР, ЭМНЭЛЭГТ НАС БАРАЛТЫН ХУВЬ

- Хүн амын нас баралтын тэргүүлэх 10 шалтгаан (НБТШ) нь тайлант жилд бүртгэгдсэн нас баралтын түвшингээр тэргүүлж буй эхний 10 өвчнөөр нас барсан хүний тоогоор илэрхийлэгдэнэ.

$$\text{Хүн амын нас баралт, тэргүүлэх 10 шалтгаанаар} = \frac{\text{Тухайн жилд бүртгэгдсэн нас баралтын тэргүүлэх тохиолдлын тоо}}{\text{Хүн амын жилийн дундаж тоо}} * 10\,000$$

- Эмнэлэгт нас баралтын хувь (ЭНБХ) нь тухайн жилд нийт нас барсан тохиолдлоос эмнэлэгт нас барсан хүний тоог хувиар илэрхийлнэ.

$$\text{Эмнэлэгт нас баралтын хувь} = \frac{\text{Эмнэлэгт нас барсан хүний тоо}}{\text{Нийт нас баралтын тоо}} * 100$$

ӨВЧЛӨЛТ



- Хүн амын дунд тохиолдох нийт өвчлөлт нь нөхөн үржихүйн бүхий л талд сөрөг нөлөө үзүүлдэг.
- Өвчлөлтийн давтамж, гарах шалтгаан, тархалтыг судалснаар тухайн төрлийн өвчлөлтөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах арга замыг тодорхойлох бололцоо бий болдог.

ӨВЧЛӨЛТ



□ Өвчлөлийн түвшин (ӨТ) нь тайлант жилд 10 000 эсвэл 100 000 хүн амд ногдох шинээр бүртгэгдсэн тухайн өвчний тохиолдлын тоогоор илэрхийлэгдэнэ.

$$\text{Өвчлөлийн түвшин} = \frac{\text{Тухайн жилд шинээр бүртгэгдсэн тохиолдлын тоо}}{\text{Хүн амын жилийн дундаж тоо}} * 10\,000$$



АМБУЛАТОРИ, СТАЦИОНАРИЙН ӨВЧЛӨЛ, ТЭРГҮҮЛЭХ 10 ШАЛТГААНААР



$$\text{Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх 10 шалтгаан} = \frac{\text{Тухайн жилд бүртгэгдсэн амбулаторийн тэргүүлэх өвчний тохиолдлын тоо}}{\text{Хүн амын жилийн дундаж тоо}} * 10\ 000$$

$$\text{Стационарийн өвчлөлийн тэргүүлэх 10 шалтгаан} = \frac{\text{Тухайн жилд бүртгэгдсэн стационарийн тэргүүлэх өвчний тохиолдлын тоо}}{\text{Хүн амын жилийн дундаж тоо}} * 10\ 000$$

5-6 НАСТАЙ ХҮҮХДИЙН ШҮД ЦООРОХ ӨВЧНИЙ ТАРХАЛТ



- 5-6 насны хүн амын дунд байгаа шүд цоорох өвчтэй (нэг буюу түүнээс дээш шүд цоорсон, нэг буюу түүнээс дээш ломбодсон, нэг буюу түүнээс дээш шүд цоорлын улмаас авагдсан шүдтэй) хүүхдийн тоог хувиар илэрхийлнэ. **(ТХЗ. Зорилт-11.6.7)**

$$\begin{array}{l} \text{5-6 настай} \\ \text{хүүхдийн шүд} \\ \text{цоорох өвчний} \\ \text{тархалт} \end{array} = \frac{\text{Шүд цоорох өвчтэй 5-6 настай} \\ \text{хүүхдийн тоо}}{\text{5-6 настай нийт хүүхдийн} \\ \text{тоо}} * 100$$

НӨХӨН ҮРЖИХҮЙ, ГЭР БҮЛ ТӨЛӨВЛӨЛТ



- **Гэр бүл төлөвлөлт** нь хувь хүн, гэр бүлийн хосууд өөрсдийн эрүүл мэнд, эдийн засаг, амьдралын байдалд тохируулан хүссэн цагтаа жирэмслэж, хүссэн хүүхдээ төрүүлэх асуудлыг агуулж байдаг.
- Гэр бүл төлөвлөлтийн асуудал нь зөвхөн жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийг практикт хэрэгжүүлэх асуудлаар хязгаарлагдахгүй бөгөөд энэ нь нөхөн үржихүйн стратегийн асуудал юм.
- Гэр бүл төлөвлөлтийн хөтөлбөр нь олонхи оронд эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах гол чухал хэрэгсэл болдог.

НЯЛХАС, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хэрэгждэг хөтөлбөр, төслүүдийн үр дүнг үнэлэх

Эх хүүхдэд үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг үнэлэх

Эрсдэл өндөртэй газар зүйн бүс нутаг, хүн амын бүлгийг тогтоож, хэрэгжүүлэх арга хэмжээний стратеги боловсруулах

Эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хэрэгждэг хөтөлбөр, төслүүдийн үр дүнг үнэлэх

Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хэрэгждэг хөтөлбөр, төслүүдийн үр дүнг үнэлэх



НЯЛХСЫН БОЛОН 5 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙН ТҮВШИН (1000 АМЬД ТӨРӨЛТ ТУТАМД)



- Амьд төрсөн 1 000 хүүхдэд ногдох, нэг хүртэлх насандаа /0-364 хоногтой/ эндсэн хүүхдийн тоог илэрхийлнэ. Нэг хүртэлх насны хүүхдэд 0-11 сар 28 хоногтой хүүхдийг хамруулна. **(МХЗ. Зорилт-9.4.1)**

$$\text{Нялхсын эндэгдлийн түвшин} = \frac{\text{Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо}}{\text{Нийт амьд төрөлтийн тоо}} * 1\,000$$

- Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог илэрхийлнэ. 5 хүртэлх насны хүүхдэд 0 наснаас 4 нас 364 хоногтой хүүхдийг хамруулна. **(МХЗ. Зорилт-9.4.2)**

$$\text{Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин} = \frac{\text{Тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо}}{\text{Нийт амьд төрөлтийн тоо}} * 1\,000$$



□ *Жирэмсний эрт үеийн хяналтын хувь:*

Жирэмсний эрт үеийн хяналтын хувийг тооцохдоо эхний 3 сартайд жирэмсний хяналтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн тоог шинээр бүртгэгдсэн жирэмсэн эмэгтэйчүүдийн тоонд харьцуулж, 100-аар үржүүлнэ.

$$\begin{array}{l} \text{Жирэмсний эрт} \\ \text{үеийн хяналтын} \\ \text{хувь} \end{array} = \frac{\begin{array}{l} \text{Эхний 3 сартайд хяналтанд} \\ \text{хамрагдсан жирэмсэн} \\ \text{эмэгтэйчүүдийн тоо} \end{array}}{\begin{array}{l} \text{Шинээр бүртгэгдсэн жирэмснээс} \\ \text{хяналтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн} \\ \text{тоо} \end{array}} * 100$$



□ Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь:

Жирэмсний үед эмнэлгийн хяналтанд хамрагдаж, зөвлөгөө авах, эх барих, шинээр төрсөн хүүхдийг асрах талаар тусгайлан сургасан эмнэлгийн ажилтны эх барьсан төрөлтийн тоогоор илэрхийлэгдэнэ. **(ТХЗ. Зорилт-10.5.2)**

$$\begin{array}{l} \text{Эрүүл мэндийн} \\ \text{мэргэжлийн} \\ \text{ажилтан эх} \\ \text{барьсан} \\ \text{төрөлтийн хувь} \end{array} = \frac{\begin{array}{l} \text{Эрүүл мэндийн мэргэжлийн} \\ \text{ажилтан эх барьсан төрөлтийн} \\ \text{тоо} \end{array}}{\begin{array}{l} \text{Нийт төрөлтийн тоо} \end{array}} * 100$$



Жирэмслэхээс хамгаалах арга хэрэгслийн орчин үеийн хэрэглээний арга хэрэгсэл $\bar{a}y\bar{a}y\bar{a}o$ бэлгэвч (эрэгтэй, эмэгтэй) ерөндөг, суулгац (дааврын), жирэмслэхээс сэргийлэх эм, тариа, үтрээний хаалт, умайн хүзүүний таглаа, үрийн суваг, умайн гуурс боох мэс ажилбар зэрэг хамаарна.

$$\begin{array}{l} \text{Жирэмслэхээс} \\ \text{хамгаалах орчин} \\ \text{үеийн арга} \\ \text{хэрэглээний хувь} \end{array} = \frac{\begin{array}{l} \text{Жирэмслэхээс хамгаалах хэрэгслийн} \\ \text{орчин үеийн аргын аль нэгийг} \\ \text{хэрэглэдэг нөхөн үржихүйн насны (15-} \\ \text{49) насны нийт эмэгтэйчүүдийн тоо} \end{array}}{\begin{array}{l} \text{Нөхөн үржихүйн насны (15-49)} \\ \text{насны нийт эмэгтэйчүүдийн тоо} \end{array}} * 100$$



Зургаа ба түүнээс дээш удаа жирэмсний хяналтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь

Зургаа ба түүнээс дээш удаа жирэмсний хяналтанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь:

Нөхөн үржихүйн болон гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийн явц, жирэмсэн үед үзүүлж буй тусламж үйлчилгээний хүртээмжийг тодорхойлох, жирэмсний хяналт стандартын дагуу явагдаж буй эсэхийг хянах, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд ашигладаг.

$$\begin{array}{l} \text{Зургаа ба түүнээс} \\ \text{дээш удаа жирэмсний} \\ \text{хяналтанд} \\ \text{хамрагдсан жирэмсэн} \\ \text{эмэгтэйчүүдийн эзлэх} \\ \text{хувь} \end{array} = \frac{\text{Жирэмсний хяналтанд 6 ба түүнээс} \\ \text{дээш удаа хамрагдсан эмэгтэйчүүдийн} \\ \text{тоо}}{\text{Нийт төрсөн эхийн тоо}} * 100$$



ҮР ХӨНДӨЛТ



- Жирэмсний 22 долоо хоног хүртэл хугацаанд эмнэлгийн цэвэр, ая тухтай орчинд жирэмслэлтийг эмнэлгийн аргаар таслах мэс ажилбарыг **үр хөндөлт** гэнэ.
- Жирэмсний эхний 12 долоо хоног дотор үр хөврөлийг авах ажилбарыг **эрт үеийн**, 13-22 долоо хоног хүртэл хугацаанд ураг авах ажилбарыг **хожуу үеийн үр хөндөлт** хэлнэ.

ҮР ХӨНДӨЛТ



□ Хувийн эмнэлгүүдэд хийгдэж буй үр хөндөлтийн тоо дутуу бүртгэгддэг тул энэхүү үзүүлэлтийг ашиглахад бэрхшээл учирдаг. Бүрэн мэдээлэгдсэн тохиолдолд дараах зорилгоор ашиглах боломжтой. Үүнд:

- Гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөр, төслүүд ба тэдгээрийн хэрэгжилтийг үнэлэх
- Үр хөндөлтийн түвшин өндөртэй бүс нутаг, хүн амын бүлгийг тогтоох

ҮР ХӨНДӨЛТИЙН ХАРЬЦАА, КОЭФФИЦИЕНТ



□ Үр хөндөлтийн харьцаа

$$\text{Үр хөндөлтийн харьцаа} = \frac{\text{Үр хөндөлтийн тоо}}{\text{Нийт амьд төрөлтийн тоо}} * 1000$$

□ Үр хөндөлтийн тусгай коэффициент;

$$\text{Үр хөндөлтийн тусгай коэффициент} = \frac{\text{Үр хөндөлтийн тоо}}{\text{Нөхөн үржихүйн насны (15-49) насны нийт эмэгтэйчүүдийн тоо}} * 1000$$



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ



□ **Нэг их эмч (сувилагч)-д ногдох хүний тоо:** Уг үзүүлэлтийг мэргэжил тус бүрээр тооцож гаргаж болно. Үүнд:

- Эмчийн хүртээмж, ачааллыг үнэлэх
- Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг төлөвлөх, хэрэгцээг тооцох
- Эмчийн хүртээмж, ачааллыг бүс нутгаар харьцуулах



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ



- Хүн амын жилийн дундаж тоог нийт их эмч (сувилагч)-ийн тоонд харьцуулна.

Нэг иргэний жилд
эмнэлэгт
үзүүлсэн дундаж
тоо

=

Амбулаторийн нийт үзлэгийн тоо

Хүн амын жилийн дундаж тоо



Урьдчилсан
Мэдээлэл
2024




МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, ДАВТАМЖ

ЭМЯ-ны захиргааны тайлан
мэдээ жилд 1 удаа

ЭМЯ-ны Хүн ам, өвчлөл,
эндэгдлийн сар, жилийн
мэдээ



МЭДЭЭЛЛИЙН ЗАДАРГАА





МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ



Статистикийн сарын бюллетень,
танилцуулга

Статистикийн жилийн эмхтгэл

ҮСХ-ны вэб сайт www.1212.mn



ᠠᠨᠬᠠᠠᠷᠠᠯᠤᠬᠠᠨᠳᠤᠭᠤᠯᠤᠰᠠᠨᠳᠤᠨᠪᠠᠶᠠᠷᠯᠠᠯᠠᠭᠠ



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.